



БНМАУ  
УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН  
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ

ЗАХИРАМЖ

1993 оны 2 сарын 4 өдөр

Дугаар А/14

Улаанбаатар хот

Улсын үйлдвэрийн газар /УУГ/  
сайгуулах тухай

1. Улаанбаатар-Бээжин хотын хамтын ажиллагаа, хэлэлцээрийн дагуу Улаанбаатар хотод барьж ашиглалтанд орсон өнгөт бетонон хавтан үйлдвэрлэх хамтын үйлдвэрийн монголын талын түр захиргааг "Шоо" компани /УУГ/ болгон 1993 оны 2 дугаар сарын 1-нээс ажиллуулсугай.

2. "Шоо" компани /УУГ/-ийн дүрмийн санг 1621,2 мянган төгрөгөөр тогтоож, дүрмийг хавсралтаар баталсугай.

3. Компаний захирлаар Лувсантувааны Доржпүрэвийг томилсугай.

4. Үйлдвэрлэлийн хэвийн ажиллагааг хангах, мэргэжилтэн, ажилчдын үйлчилгээнд зориулан автомашин Газ-53, автосамосвал машин МНЗ-555 тус бүр 1-ийг "Шоо" компанид балансаас балансад шилжүүлэн өгөхийг Тохижилт компани /н.Нямсүрэн/-д зөвшөөрсүгэй.

5. Энэ захирамж гарсантай холбогдуулж Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны 1992 оны 156 дугаар тогтоолын шууд хамаарагдах заалтуудыг хүчингүй болсонд тооцсугай.



МЭНДЭЛЭЛИЙН ЗАСАГ  
ДАРГА

Ц.БААСАНЖАВ



Нийслэлийн Засаг даргын 1993 оны  
12/14 тоот захирамжаар батлав.

**БҮРЭН БУС ХАРИУЦЛАГАТАЙ "ШОО"  
КОМПАНИЙН /ХҮГ/ ДҮРЭМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Үйлдвэрлэл үйлчилгээний бүрэн бус хариуцлагатай /ББХ/ "Шоо" компани /цаашид компани гэж нэрлэнэ/ нь үйлдвэрлэл үйлчилгээний ажил эрхлэх бөгөөд өөрийн үйл ажиллагаатай холбогдсон үүргийг эд хөрөнгөөрөө хариуцсан хуулийн этгээдийн эрх бүхий бие даасан аж ахуйн нэгж мөн.

2. "Шоо" компани нь өөрийн үйл ажиллагаагаа Монгол улсын хуулиуд болон нийслэлийн засаг даргын захирамжаар батлагдсан энэхүү дүрмийн хүрээнд эрхлэн явуулна.

3. "Шоо" компани нь Нийслэлийн Засаг даргын захирамжаар байгуулагдан ажлаа хариуцан тайлагнана.

4. Компани нь өөрийн үйл ажиллагаа явуулахдаа тогтоосон журмын дагуу хийсэн тэмдэг, албан бичиг, тушаалын хэвлэмэл хуудас хэрэглэх бөгөөд банкинд /төгрөгийн ба валютын/ харилцах данстай байна.

5. Компанийн захирлыг нийслэлийн Засаг даргын захирамжаар томилно.

Хоёр. Компанийн эрхлэх ажил

6. Компани нь өөрийн хүчин чадварт түшиглэн нийслэл хотын, хот нийтийн эзэмшлийн зам талбайг тохижуулах ажилд зориулан төрөл бүрийн бетонон хавтан үйлдвэрлэх болон зам талбайг шинээр хийх, засварлах, өргөтгөх, шинэчлэх ажлыг эрхлэнэ.

7. Компани нь үйлдвэрлэл үйлчилгээний бүхий л үйл ажиллагаагаа өөрийн ажилтан ажиллагчийн хүчээр гүйцэтгэх бөгөөд олсон орлогоороо үйлдвэрлэл үйлчилгээг явуулна.

Шаардлагатай үед гэрээгээр түр нэмэгдэл хүч авч ажиллуулж болно.

8. Компанийн захирал нь нийгмийн хэрэгцээ, үйлдвэрлэлийн техник, технологи эдийн засгийн хөгжлийн шаардлагуудад нийцүүлэн үр бүтээлтэй ажиллах чадвартай, ажил хэргийн өндөр мэдлэгтэй боловсон хүчнээр аппаратыг бүрдүүлж, тэднээс эрхэлсэн ажлаа бие дааж санаачлагатай гүйцэтгэх талаар тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллана.

Гурав. Компанийн дүрмийн саягийн хэмжээ, ашиг алдардлыг хуваарилах

9. Компанийн бүх хөрөнгө төрийн өмчид хамраарагдах бөгөөд өөрийн үйл ажиллагааны дунд олох ашиг орлого нь компанийн санхүүгийн эх үүсвэр болно.

10. Компанийн дүрмийн сан /үндсэн хөрөнгө, эд зүйл, мөнгөн хэлбэрээр/ нийслэлийн Засаг даргын захирамжаар тогтоосон хэмжээнд =1621,2 мянган төгрөг байна.

11. Компанийн барилга байгууламж, тоног төхөөрөмж, эд хогшил, багаж хэрэгсэл, бараа бүтээгдэхүүн, сэлбэг материал, түүхий эд, мөнгөн хөрөнгө зэрэг эд хөрөнгөтэй байх бөгөөд тэдгээр нь хуулиар хамгаалагдана.

12. Компанийн үйл ажиллагааны буруугаас бусад байгууллагад үзүүлсэн хохирол, гэрээний торгуулийг өөрийн үндсэн хөрөнгөөс төлж, бусад газраас төлсөн торгуулийг өөрийн мэдлийн сэнд оруулна.

13. Компани нь цэвэр орлогоосоо хуулинд заасан хэмжээгээр татвар төлнө.

14. Компани нь өөрийн мэдлийн хөрөнгийг өөр газар байгууллагад худалдах, шилжүүлэх бол нийслэлийн Засаг даргын тамгын газраас зөвшөөрөл авч байна.

15. Компани нь үйлдвэрлэл үйлчилгээний үйл ажиллагаагаа өргөтгөх зорилгоор дүрмийн сангаа нэмэгдүүлэх эрхтэй.

Дөрөв. Компанийн үүрэг

16. Компани нь банк, санхүү, статистикийн байгууллагад тэдгээрээс тогтоосон журмын дагуу мэдээ, тайлангаа үнэн зөв хугацаанд нь тогтмол мэдээлж байна.

17. Өөрийн үйл ажиллагаатай холбогдон үүсэх үүргийг эд хөрөнгөөрөө бүрэн хариуцна.

18. Үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэхдээ техник, технологи, эрүүл ахуйн болон байгаль орчныг хамгаалахтай холбогдсон шаардлагыг бүрэн хангана.

3.

19.Гадаадн байгууллагатай ашигтай худалдаа хийж техник технологи нэвтрүүлэх, хэрэглэгчдийн шаардлага хангасан чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэж, ажил үйлчилгээ явуулах талаар аж ахуйн бүрэн тооцоотой бие дааж хамтран ажиллана.

20.Өөрийн болон гадаад орны банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл, бусад төлбөрийн тооцоог гэрээнд заасан хугацаа нөхцлийн дагуу төлж барагдуулна.

21.Ажилтан болон гэрээгээр ажиллагчдын нийгмийн асуудлыг зохих шаардлагын дагуу шийдвэрлэнэ.

Тав.Компанийн эрх

22.Компани нь хуульд заасны дагуу гадаад худалдаа, үйлдвэрлэл үйлчилгээний үйл ажиллагааг бие даан явуулна.

23.Өөрийн үйл ажиллагаатай холбогдсон асуудлаар өөрийн болон гадаад орны үйлдвэр, пүүс, компани, бусад байгууллагатай шууд харилцаа тогтоон гэрээ хэлэлцээр хийж хамтран ажиллах эрх эдлэнэ.

24.Шаардлагатай тохиолдолд компанийн салбарыг Монгол улсын нутаг дэвсгэрийн аль ч хэсэгт байгуулж болно.

25.Үйлдвэрлэл үйлчилгээний үр ашгийг дээшлүүлэх, дампуурлаас сэргийлэх зорилгоор өөрийн салбар нэгжүүдийн бүтэцийг өөрчлөх /өргөтгөх, татан буулгах/ эрх эдлэнэ.

Зургаа.Компанийн үйлдвэрлэл, удирдлагын зохион байгуулалтын бүтэц

26.Компанийн удирдах бүрэн эрхийг захирал хэрэгжүүлнэ.

27.Компанийн удирдлага, ажилтан ажилчдын хурлыг жилд I-ээс доошгүй удаа хийнэ.

Дор дурьдсан асуудлыг хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ. Үүнд:

- а/Тайлан тэнцэл, ашиг хуваарилах;
- б/Ажилтан ажилчдын бүрэлдэхүүнд өөрчлөлт орох;
- в/Ажилтан ажилчдыг сонгох, чөлөөлөх, түүнд олгох цалин хөлсийг тогтоох;
- г/Компанийг өөрчлөн байгуулах /нийлүүлэх, нэгтгэх, салгах, тусгаарлах/ үйл ажиллагааг нь зогсоох;
- д/Тэрээ, дүрэм, нэмэлт өөрчлөлт оруулах;
- е/Тэрээнд заасан бусад зүйл.

28. Нийт ажилтан ажиллагсдын хурлыг захирал зарлай хуралдуулах бөгөөд хэлэлцэх асуудлыг хурал эхлэхээс 14 хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ.

29. Хэлэлцэхээр төлөвлөөгүй асуудлыг зөвхөн хуралд оролцож байгаа нийт ажиллагсдын зөвшөөрснөөр хэлэлцэж болно. Энэ нь саналын хувиас шалтгаалан хойшлогдсон хуралд хамаарахгүй.

30. Нийт ажилтнууд нь хуралдахгүйгээр шийдвэр гаргаж болно. Иймн шийдвэрийн төслийг бичгээр мэдэгдэх бөгөөд ажилтнууд төсөлд мөн бичгээр санал өгнө. Ажилтнуудаас ирүүлсэн саналын дүн, гаргасан шийдвэр түүний хугацааг компанийн захирал хамгийн сүүлийн санал хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор бичгээр мэдэгдэнэ.

31. Ажилтан ажиллагсдын хуралд асуудал хэлэлцүүлэхээр компанийн ажилтан бүр санал оруулах эрхтэй.

32. Хурлаас гаргасан шийдвэрийн бүртгэлийг компанийн /ерөнхий/ захирал хөтлөнө.

33. Захирал дор дурьдсан эрх эдэлж үүрэг хүлээнэ. Үүнд:

а/Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдана.

б/Компанийн хуралд ажлаа хариуцан тайлагнана.

в/Компанийг төлөөлж харилцана.

г/Тухайн компанид хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчидтай компанийг төлөөлөн гэрээ байгуулна.

д/Компанийн ажилтан ажилчдын бүртгэлийг хөтлөх бөгөөд бүртгэлд нэр хаяг, нэмэлт ажилд гүйцэтгэх үйлчилгээ хийх тухай хүлээсэн үүрэг зэргийг бичнэ.

е/Тайлан тэнцэл болон компанийн эд хөрөнгийг хурлаар хэлэлцүүлэхийн хамт компанийн үйл ажиллагааны талаар ажилтан ажилчдал мэдээлэх, санхүүгийн болон бусад бичиг баримттай танилцах боломж тэдэнд олгоно.

ж/Компаниас гарсан мэдээ мэдээллийн үнэн зөвийг хариуцна.

з/Салбар, нэгжийн дарга, албан тушаалтныг томилох, чөлөөлөх.

Долоо. Компанийн ажилтны үүрэг, эрх

31. Компанийн ажилтнууд дор дурьдсан үүрэг хүлээнэ. Үүнд:

а/Захиралтай байгуулсан гэрээ хэлцэлийг хатуу баримтлана.

211

5.

б/Монгол улсын хөдөлмөрийн хуулийн заалтыг чанд бие-  
лүүлж үнэнч шударга хөдөлмөрлөх.

35.Компанийн ажилтнууд дор дурьдсан эрхийг эдлэнэ. Үүнд:

а/Ногдох хувь эзэмших эрхийг шилжүүлэх тохиолдолд тэр-  
гүүн ээлжинд худалдаж авах;

б/Компаниас гарах тохиолдолд захиргаатай байгуулсан гэр-  
рээ хэлэлцлийн дагуу цалин, хөрөнгийн үнийг эргүүлэн авах.

в/Компанийн үйл ажиллагаатай холбогдолтой мэдээлэл  
авах, бичиг баримттай биечлэн танилцах.

Найм.Компанийг татан буулгах эцсийн тооцоо хийх

36.Компанийн үйл ажиллагааг дор дурьдсан үндэслэлээр зог-  
соож болно. Үүнд:

а/Тухайн бүтээгдэхүүн ажил үйлчилгээг эрхлэх боломжгүй  
болсон үед нийслэлийн Засаг даргын шийдвэрээр;

б/Шүүхийн шийдвэрээр;

в/Улсын хууль дүрэмд заасан бусад үндэслэлээр.

37.Компанийн үйл ажиллагааг зогсоосон нөхцөлд эцсийн тооцоо  
хийх бөгөөд /36/-ийн "б"-д зааснаас бусад тохиолдсд түүнийг  
захирал гүйцэтгэнэ.

38.Эцсийн тооцоог "Монгол улсын Аж ахуйн нэгжийн тухай"  
хуульд зааснаар гүйцэтгэх бөгөөд өр төлбөрийг төлсний дараа  
ажилтан ажилчдын хувь хөрөнгийг биет байдлаар эргүүлэн өгөх  
бууу үнийг төлнө.